

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ЭРЭЛТ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Санал асуулгын тайлан

[... Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн нь шүүхийг арга зүй, мэдээллээр хангах хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд мөн шүүгчдийн судалгаа, сургалт, мэдээллийн эрэлт хэрэгцээг бодитой, оновчтой тодорхойлох үүднээс энэхүү эрэлтийн судалгааг авч цаашидын үйл ажиллагаа, төлөвлөгөөнд тусгах зорилгоор хийж байгаа болно...]

Хянасан:

С. Билгүүн /Ахлах референт/

Тайланг нэгтгэн боловсруулсан:

Д.Аюуш /Социологич судлаач/

Тайланг боловсруулсан:

С.Алтанхуяг /Референт/

Ц.Ариунболд /Судлаач/

АГУУЛГА

УДИРТГАЛ ХЭСЭГ

- Судалгааны зорилго ба хамрах хүрээ
- Судалгааны мэдээлэл цуглуулах арга
- Судалгааны түүвэр
- Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээллийг боловсруулсан байдал

СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ

1. Судалгааны ажлын хураангуй
2. Салбар эрх зүйн чиглэлээр
3. Шүүн таслах ажиллагааны ур чадвар
4. Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн хүчин зүйлийг тооцох
5. Хувь хүний хөгжлийн чиглэлээр
6. Салбар хоорондын мэдлэг, ур чадвар хөгжүүлэх

САНАЛ ЗӨВЛӨМЖ



УДИРТГАЛ ХЭСЭГ

- Судалгааны зорилго ба хамрах хүрээ

Монгол Улсын анхан болон давж заалдах шатны Шүүхийн шүүгчдийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс ямар бүтээгдэхүүн авах талаар эрэлт хэрэгцээг бодитой оновчтой тодорхойлох нь судалгааны зорилго юм.

Дээрх зорилгод үндэслэн шүүгчдийн судалгаа, мэдээлэл, сургалтын хэрэгцээг дараах байдлаар томъёолж, судалгааны хэрэглэгдэхүүн (*асуулга*) боловсруулан мэдээлэл авч, үр дүнд тулгуурлан энэхүү тайланг бичлээ.

- Салбар эрх зүйн чиглэлээр
- Шүүн таслах ажиллагааны ур чадвар
- Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн хүчин зүйлийг тооцох
- Хувь хүний хөгжлийн чиглэлээр
- Салбар хоорондын мэдлэг, ур чадвар хөгжүүлэх

- Судалгааны мэдээлэл цуглуулах арга

Анкетын судалгаа¹:

- Судалгааны түүвэр

Монгол Улсын анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд нэлэнхүй түүврийн аргаар судалгааг авсан. Асуулгыг хамгийн багадаа нийт² шүүгчдийн 60.4 хувь буюу 235 шүүгчээс авсан болно. Доор ямар шүүхийн тамгын газраас хэдэн асуулга авсаныг задлаж үзүүлэв:

Хүснэгт № 1 Судалгааны түүвэр

| № | Аймаг, сумдууд | Шүүхүүд | Шүүгчдийн тоо | Асуулгын тоо |
|---|--|---|---------------|--------------|
| 1 | Ховд аймаг /Жаргалант, Булган сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх | 4 | 4 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх | 4 | 3 |
| | | Сум дундын 25 дугаар шүүх | 3 | 3 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүх | 1 | 1 |
| | | Сум дундын 26 дугаар шүүх | 3 | 0 |
| 2 | Баян-Өлгий аймаг | Сум дундын 2 дугаар шүүх | 6 | 4 |

¹ Хавсралтаар үзүүлэв

² 389 шүүгч, Дээд шүүхийн шүүгчид ороогүй 2014.01.08

| | | | | |
|----|---|---|---|---|
| | /Өлгий сум/ | Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүх | 3 | 2 |
| 3 | Увс аймаг /Улаангом сум/ | Сум дундын 24 дүгээр шүүх | 4 | 4 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүх | 2 | 2 |
| 4 | Дундговь аймаг /Сайнцагаан сум/ | Сум дундын 11 дүгээр шүүх | 4 | 3 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 9 дүгээр шүүх | 2 | 1 |
| 5 | Өмнөговь аймаг /Даланзадгад, Ханбогд сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүх | 3 | 2 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүх | 3 | 2 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүх | 1 | 1 |
| | | Сум дундын 15 дугаар шүүх | 4 | 2 |
| | | Сум дундын 16 дугаар шүүх | 5 | 3 |
| 6 | Дорноговь аймаг /Сайншанд, Замын-Үүд сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүх | 3 | 2 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүх | 3 | 2 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 7 дугаар шүүх | 2 | 2 |
| | | Сум дундын 8 дугаар шүүх | 4 | 3 |
| | | Сум дундын 9 дүгээр шүүх | 4 | 4 |
| 7 | Говьсүмбэр аймаг /Сүмбэр сум/ | Сум дундын 6 дугаар шүүх | 4 | 4 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүх | 3 | 1 |
| 8 | Завхан аймаг /Улиастай, Тосонцэнгэл сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүх | 3 | 3 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүх | 3 | 3 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүх | 2 | 2 |
| | | Сум дундын 12 дугаар шүүх | 5 | 5 |
| | | Сум дундын 13 дугаар шүүх | 3 | 3 |
| 9 | Говь-Алтай аймаг /Есөнбулаг сум/ | Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх | 2 | 2 |
| | | Сум дундын 5 дугаар шүүх | 5 | 5 |
| 10 | Сэлэнгэ аймаг /Сүхбаатар, Мандал, Сайхан сум/ | Сум дундын 20 дугаар шүүх | 6 | 4 |
| | | Сум дундын 21 дүгээр шүүх | 3 | 0 |
| | | Сум дундын 22 дугаар шүүх | 3 | 1 |
| 11 | Сүхбаатар аймаг /Баруун-Урт сум/ | Сумд дундын 19 дүгээр шүүх | 5 | 0 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүх | 2 | 0 |
| 12 | Дархан-Уул аймаг /Дархан сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүх | 4 | 3 |

| | | | | |
|----|--|---|---|---|
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүх | 5 | 5 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүх | 5 | 0 |
| | | Сум дундын 7 дугаар шүүх | 8 | 6 |
| 13 | Орхон аймаг /Баян-Өндөр сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүх | 5 | 4 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүх | 4 | 4 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 11 дугаар шүүх | 5 | 1 |
| | | Сум дундын 14 дүгээр шүүх | 6 | 6 |
| 14 | Булган аймаг /Булган сум/ | Сум дундын 4 дүгээр шүүх | 4 | 2 |
| 15 | Өвөрхангай аймаг /Арвайхээр, Хархорин сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүх | 4 | 2 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүх | 4 | 2 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүх | 2 | 1 |
| | | Сум дундын 17 дугаар шүүх | 4 | 0 |
| | | Сум дундын 18 дугаар шүүх | 3 | 0 |
| 16 | Архангай аймаг /Эрдэнэбулган сум/ | Сум дундын 1 дүгээр шүүх | 5 | 0 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх | 2 | 4 |
| 17 | Баянхонгор аймаг /Баянхонгор сум/ | Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүх | 2 | 2 |
| | | Сум дундын 3 дугаар шүүх | 4 | 4 |
| 18 | Дорнод аймаг /Хэрлэн сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүх | 5 | 5 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүх | 6 | 3 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүх | 3 | 2 |
| | | Сум дундын 10 дугаар шүүх | 9 | 6 |
| 19 | Төв аймаг /Зуун мод сум/ | Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүх | 3 | 1 |
| | | Сум дундын 23 дугаар шүүх | 9 | 2 |
| 20 | Хөвсгөл аймаг /Мөрөн сум/ | Иргэн хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүх | 3 | 0 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүх | 3 | 3 |
| | | Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүх | 2 | 0 |
| | | Сум дундын 27 дугаар шүүх | 8 | 0 |

| | | | | |
|----|--|--|------------|------------|
| 21 | Хэнтий аймаг /Хэрлэн, Бор-өндөр сум/ | Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүх | 2 | 0 |
| | | Сум дундын 28 дугаар шүүх | 4 | 0 |
| | | Сум дундын 29 дүгээр шүүх | 3 | 1 |
| 22 | Улаанбаатар хот | Дүүргийн Иргэний хэргийн 1 дүгээр шүүх | 23 | 19 |
| 23 | Улаанбаатар хот | Дүүргийн Иргэний хэргийн 2 дугаар шүүх | 23 | 12 |
| 24 | Улаанбаатар хот | Дүүргийн Эрүүгийн хэргийн 1 дүгээр шүүх | 22 | 8 |
| 25 | Улаанбаатар хот | Дүүргийн Эрүүгийн хэргийн 2 дугаар шүүх | 23 | 9 |
| 26 | Улаанбаатар хот /Багануур дүүрэг/ | Дүүргийн Иргэний хэргийн 3 дугаар шүүх | 3 | 1 |
| | | Дүүргийн Эрүүгийн хэргийн 3 дугаар шүүх | 3 | 3 |
| 27 | Улаанбаатар хот /Налайх дүүрэг/ | Дүүргийн Эрүүгийн хэргийн 4 дүгээр шүүх | 4 | 1 |
| | | Дүүргийн Иргэний хэргийн 4 дүгээр шүүх | 2 | 2 |
| 28 | Улаанбаатар хот | Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх | 9 | 8 |
| 29 | Улаанбаатар хот | Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх | 4 | 4 |
| 30 | Улаанбаатар хот | Иргэн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх | 8 | 8 |
| | | Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх | 12 | 8 |
| 31 | Нийт | | 389 | 235 |

| | | | |
|----|--------|-----------------------|------------|
| 32 | Үүнээс | Захиргаа | 37 |
| | | Эрүү, иргэн, сум дунд | 198 |
| 33 | Нийт | | 235 |

| | | | |
|----|--------|------------------|------------|
| 34 | Үүнээс | Анхан шат | 163 |
| | | Давж заалдах шат | 72 |
| 35 | Нийт | | 235 |

| | | | |
|----|--------|------------|------------|
| 36 | Үүнээс | Орон нутаг | 152 |
| | | Нийслэл | 83 |
| 37 | Нийт | | 235 |

Мэдээллийн нууцлалыг хангах

- Судалгаа нь нэр буюу шүүгчийн овог нэрийг асуухгүй анкетын судалгааг авч дуусмагц цахимаар авч, нэгтгэн боловсруулсан.

- **Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээллийг боловсруулсан байдал**

Судалгааны мэдээллийг дан хийгээд харьцуулсан тоололтыг нийгмийн судалгааны SPSS програм дээр боловсруулж голлох үр дүнг танилцууллаа.



СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд нийт 235 шүүгч оролцсоноос нийслэлд байрладаг шүүхийн шүүгч 83, орон нутгийн шүүхийн шүүгч 152 хамрагдсан нь нийт анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 60.4 хувь нь хамрагдсан байна.

Хүн амын үзүүлэлтийн хувьд:

График №1 Хүйс






График №2 Нас



Нийт судалгаанд оролцсон шүүгчдийн дийлэнх нь буюу 153 шүүгч эмэгтэй байсан бол 78 шүүгч эрэгтэй байна. 54 хувь нь дөчөөс дээш настай байгаа бол 44 хувь нь дөчөөс доош настай байна. 30 хүртэл насны шүүгч 4 байгаа нь судалгаанд оролцсон шүүгчдийн 2 хувьтай тэнцүү байна.

График №3 Шүүгчээр ажилласан жил




Нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 41.2 хувь буюу 80 шүүгч 16-аас дээш жил ажилласан бол 28 шүүгч 5 хүртэл жил ажиллаж байгаа байна.

2. Салбар эрх зүйн чиглэлээр

2.1. Эрүүгийн эрх зүй

Эрүүгийн эрх зүйн чиглэлээр шүүгчид шүүхийн практикт маргаантай нэг мөр тогтоогүй, эсхүл шүүн таслах ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд судалгаа, мэдээлэл авах, сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэж буй асуудлуудыг дараах дэд сэдвүүдэд орон нутаг болон нийслэлээр харьцуулж үзвэл:

График №4 Насанд хүрээгүй этгээдтэй холбоотой



Насанд хүрээгүй этгээдтэй холбоотой сэдвүүдээс нийслэл болон орон нутагт хүүхдэд ял оногдуулах онцлог, ял шийтгэл, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний төрлүүд, тэдгээрийн үр нөлөө хамгийн их тулгамдсан асуудал гэж үзсэн байна. Харин насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх онцлог-ийг орон нутгийн шүүгчид тулгамдсан асуудлын хоёрдугаарт дурдсан байна. Шүүхийн статистик мэдээллээс үзвэл ял шийтгүүлэгчдийн нас “залуужиж”, 14-15 настай ял шийтгүүлэгчдийн тоо өсч байгаа нь энэ чиглэлээр шүүхийн сургалтын хөтөлбөр боловсруулах, шүүхийн практикийг судлах шаардлагатайг харуулж байна.

Мөн шүүгчдээс “насанд хүрээгүй этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл, журам”, “хүүхэд гэмт хэрэг үйлдэх сэдэл, шалтгаан, гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал”, “насанд хүрээгүй этгээдэд оногдуулах хорих ялын альтернатив төрлүүд” зэрэг ач холбогдолтой сэдвүүдийг нэмэлт байдлаар дурдсаныг судалгаа, мэдээллээр хангах, сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулахад анхаарах нь зүйтэй байна.

График №5 Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр нэвтрүүлж буй ойлголт, чиг хандлагын талаар:



Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр нэвтрүүлж буй ойлголт, чиг хандлагын хувьд орон нутагт ял тохиролцох тухай ойлголт, нийслэлийн шүүхийн шүүгчдэд ялын шинэ төрлүүд, тэдгээрийн үр нөлөө болон эрүүгийн процессын эрх зүйн тогтолцооны тухай судалгаа, мэдээлэл авах, сургалтад оролцох эрэлт хэрэгцээ өндөр байна.


Шүүгчдээс шинээр боловсруулсан хуулиудын төсөлтэй холбоотойгоор “албан тушаалын гэмт хэрэг”, “зарчмын шинжтэй орж буй өөрчлөлтүүд” зэрэг чиглэлийг чөлөөт сонголтот хэсэгт дурджээ.

График №6 Хуулийн этгээдийн эрүүгийн эрх зүйн хариуцлага:



Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нэвтэрч буй шинэ ойлголт болох хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой сэдвээс нийслэл дэх шүүгчдэд бусад орны эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, туршлага нэн тэргүүнд хэрэгцээтэй байгаа бол орон нутгийн шүүхийн шүүгчдэд хуулийн этгээдэд оногдуулах ялын ойлголт, төрлүүдийн талаар судалгаа мэдээлэл шаардлагатай байгаа нь харагдаж байна.


График №7 Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг:



Хувь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах үйлдлийн талаар нийт шүүгчид судалгаа, мэдээлэл авах, сургалтад оролцох хэрэгцээтэй байгааг илэрхийлжээ. Мөн бүх шатны сонгууль, ард нийтийн санал хураалтын явцад үйлдэгддэг гэмт хэрэг, түүнийг хянан шийдвэрлэсэн шүүхийн практикийг судлах хүсэлтийг гаргасан байна.


Харьцангуй шинэ боловч сүүлийн үед мөнгө угаах гэмт хэрэг, түүний тухай ойлголтын хүлээлт нийгэмд төдийгүй шүүгчдэд хамгийн их эрэлттэй байгаа нь харагдаж байна. Нийслэл болон орон нутгийн шүүгчид адил 72 хувь нь чухал хэрэгцээтэй гэж үзжээ.

График №8 Албан тушаалын гэмт хэрэг




Албан тушаалын гэмт хэргээс нийслэл дэх шүүхийн шүүгчид 78.6 хувь нь, орон нутгийн шүүхийн шүүгчдийн 70.4 хувь нь хууль бусаар хөрөнгөжих (үндэслэлгүйгээр хөрөнгөжих) үйлдэл, түүний эрүүгийн эрх зүйн үр дагаврыг судлах, сургалт семинарт оролцох эрэлт хэрэгцээ хамгийн өндөр байна. Мөн хэрэв эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэ хуулиуд батлагдсан тохиолдолд албан тушаалтан бусдад хууль бусаар нөлөөлөх үйлдэл, түүний шинж, илрэх нөхцөл зэрэг мэдээллийг боловсруулж түгээх нь зүйтэй байна.

График №9 Эдийн засгийн гэмт хэрэг




Албан тушаалын гэмт хэргүүд бүгд 40-50 хувийн багцаагаар эрэлт хэрэгцээтэй байгаа бол орон нутагт татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 59.7 хувиар бусад гэмт хэрэгээсээ өндөр жагсчээ.

График №10 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг:



Мэдээллийн технологийн хөгжлийг ашиглаж цахим орчинд үйлдэгддэг, хор аюул ихтэй гэмт хэргүүдээс нийслэл дэх шүүхийн шүүгчид “цахим мэдээлэлд хууль бусаар халдах” (88.5 хувь) үйлдлийн тухай мэдээлэл авах эрэлт хэрэгцээ өндөр байгаа бол орон нутагт компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх 72.1 хувиар хамгийн эрэлт хэрэгцээтэй сэдэв болж байна.

График №11 Хүрээлэн буй орчин, байгаль орчны эсрэг гэмт хэрэг




Хүрээлэн буй орчин, байгаль орчны эсрэг гэмт хэргүүдийн дотроос нийт шүүгчид ашигт малтмал хууль бусаар хайх, олборлох гэмт хэрэг, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн практикийн асуудлыг эрэлт хэрэгцээтэй сэдэв гэж үзсэн бол байгаль орчныг бохирдуулах, газар, хөрс, ус бохирдуулах гэмт хэргийн тухай судалгаа, мэдээлэл авах, сургалтад оролцох тухай эрэлт хэрэгцээг удаад нь тодорхойлжээ.

Дээрх төрлийн гэмт хэргүүдээс өөр “Эд зүйл хууль бусаар хил нэвтрүүлэх, терроризм ба зандалчлал, хүн худалдаалах, эрүүгийн хуулийн 150, 156-г ялган зүйлчлэх асуудал, хар тамхи мансууруулах бодис, эм бэлдмэл хууль бусаар олж авах”... зэрэг гэмт хэргүүдийг судлах, мэдэх эрэлт хэрэгцээ шаардлага байгааг бичгээр дурьджээ.

2.2.Иргэний эрх зүйн чиглэлээр

Иргэний эрх зүйн чиглэлээр шүүгчид шүүхийн практикт маргаантай, нэг мөр тогтоогүй, эсхүл шүүн таслах ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд судалгаа, мэдээлэл авах, сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзсэн сэдвийг дараах дэд хэсэгт хувааж, орон нутаг болон нийслэлээр харьцуулж үзвэл:

График №12 Гэрээний эрх зүйтэй холбогдсон маргаан



Иргэний эрх зүйн хүрээнд шүүхээр зонхилон шийдвэрлэгддэг гэрээний эрх зүйд холбогдох маргаанаас орон нутгийн шүүхийн шүүгчид бусдын эзэмшилд эд хөрөнгө шилжүүлэх бүлэг гэрээний зүйлчлэлийн асуудал (60.4%) тулгамдаж байгаа бол нийслэлд санхүүгийн түрээсийн гэрээтэй холбоотой маргаан (65%)-ыг судалгаа, мэдээллийн тулгамдсан сэдэвт сонгожээ. Мөн шүүгчид банкны зээлийн гэрээ, хамтран ажиллах гэрээ, бэлэглэлийн гэрээ, өв залгамжлалтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд тулгамдсан асуудлыг тодруулах, шүүхийн практикийг судлах шаардлагатай гэж нэмэлт байдлаар тодорхойлжээ.

График №13 Даатгалын эрх зүйтэй холбогдсон маргаан

Даатгалын эрх зүйтэй холбоотой маргаанаас хохирлын үнэлгээтэй холбогдсон маргааныг орон нутаг дахь шүүгчдийн 74.1 хувь нь, нийслэл дэх шүүхийн шүүгчдийн 44.7 хувь нь сонгосон бол даатгалын нөхөн төлбөр, хураамж төлөхтэй холбогдсон маргааныг нийслэл дэх шүүхийн шүүгчдийн 73.7 хувь нь, орон нутаг дахь шүүгчдийн 53.9 хувь нь тус тус сонгожээ.





График №14 Хөдөлмөрийн эрх зүйтэй холбоотой


Хөдөлмөрийн эрх зүйн хүрээнд орон нутагт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, буруу оногдуулсан тухай маргаан (72.7%), хөдөлмөрийн дотоод журам тогтоосон тушаал шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй тухай маргаан (64.8%) өндөр байгаа бол нийслэлд хөдөлмөрийн гэрээ, контракт, тэдгээрийг ялган зүйлчлэх асуудлыг эрэлт хэрэгцээтэй сэдвээр сонгожээ.



Мөн шүүгчдийн зарим нь цалин хөлс, хөдөлмөрийн гэрээний үр дүнг тооцох, тэтгэмж, нөхөн төлбөр, олговор, ажил хаялтыг хууль бусад тооцохтой холбоотой эрх зүйн зохицуулалт, гэм хорын хохирол арилгуулах, ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх чиглэлээр нэмэлт судалгаа, мэдээлэл авах, сургалт зохион байгуулах нь зүйтэй гэж тэмдэглэсэн байна.


График №15. Гэр бүлийн эрх зүйд холбогдох маргаан

Судалгаанд оролцсон шүүгчдээс гэрлэгчид хоорондын эд хөрөнгийн маргаан, түүнийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлуудыг нэн тэргүүнд судалгаа, мэдээлэл, сургалтын агуулгад оруулах нь зүйтэй гэж үзсэн байна. Мөн гэр бүлийн холбогдолтой маргааныг урьдчилан шийдвэрлэх журам, хамтран амьдрагчдын хоорондын эрх зүйн харилцаа, хүүхдийн асрамжтай холбоотой маргааныг нэмж санал хүргүүлжээ.



Шүүхийн статистик мэдээнээс үзвэл 2013 онд шүүхээр шийдвэрлэсэн гэр бүлийн эрх зүйд хамаарах нийт маргааны 79 хувийг гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан эзэлсэн байна. Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн эрх зүйн хүрээн дэх судалгаа, сургалт, мэдээллийн ажлыг гэр бүл цуцлах, хүүхдийн асрамж тогтоох, гэр бүлийн эд хөрөнгөтэй холбоотой маргаанд чиглүүлэх нь оновчтой гэж үзэж байна. Мөн хүүхэд үрчлэлт, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикийг судлах шаардлага тулгамдаж байгаа нь графикаас ажиглагдаж байна.

График №16 Хуулийн этгээдтэй холбоотой эрх зүйн маргааныг шүүхээр шийдвэрлэх асуудал




Нийслэлд компаниас их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг зөрчсөнтэй холбоотой маргаан (86.5%), орон нутагт хуулийн этгээдийн дампуурал, түүнтэй холбоотой маргааныг шүүхээс хянан шийдвэрлэхэд анхаарах зүйлс (62.2%) эрэлт хэрэгцээтэй сэдвийг сонгожээ.

Мөн шүүгчдээс компанийн эрх зүй, үнэт цаасны эрх зүйн чиглэлээр цогц сургалт авах сонирхолтой байгааг асуулгын хуудаст тэмдэглэсэн байна.

График №17 Олон улсын хувийн эрх зүйн хүрээнд


Олон улсын хувийн эрх зүйтэй холбоотой сэдвүүдэд шүүгчид нийтэд ач холбогдол өгсөн байна. Олон улсын хувийн эрх зүйн процесс, хэргийн харьяалал, олон улсын гэрээг хэрэглэх асуудал, зөрчилдөөний хэм хэмжээ зэрэг сэдвийг эрэлт хэрэгцээт судалгаа гэж үзжээ.



Дээрх төрлийн хэргүүдээс өөр “*франчайзи, түрээсийн гэрээ, компанийн нэгдэл, охин компани, ББСБ, оюуны өмч*”... зэрэг хэргүүдийг судлах, мэдэх эрэлт хэрэгцээ шаардлага байгааг бичгээр дурьджээ.


2.3.Захиргааны эрх зүйн чиглэлээр

График №18 Захиргааны байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гаргах ажиллагааны хүрээнд аль ойлголтод тодруулах, нэмэлт мэдээлэл авах шаардлагатай гэж үзэж байна вэ?



Судалгаанд хамрагдсан шүүгчдээс нийслэлд төдийгүй орон нутагт захиргааны байгууллага, албан тушаалтны хэлбэржээгүй үйл ажиллагааг нэр мөр ойлгох нэмэлт мэдээлэл авах хэрэгтэй гэж үзсэн бол захиргааны шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаа тийм ч сайн биелэдэггүй, энэ талаар ямар нэгэн шийдэлд хүрэх, үйл ажиллагааг нь сайжруулах ёстой байгаа нь энэ асуудлыг өндөр хувиар сонгосноор харагдаж байна.

График №19 Захиргааны үйл ажиллагааны эрх зүйн нэг хэлбэр-захиргааны гэрээтэй холбоотой танд тодруулах шаардлагатай мэдээлэл аль нь вэ?




Шүүгчид захиргааны гэрээний талаар авч үзэхдээ хувийн эрх зүйгээс ялган зүйлчлэх тал дээр асуудал үүсдэг талаар өндөр хувиар сонгожээ. Мөн нөгөө талдаа захиргааны эрх зүйн гэрээтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд Иргэний эрх зүйн хууль тогтоомжийг төсөөтэй хэрэглэх боломжийг эрэлхийлсэн байгаа нь харагдаж байна. Иймээс энэ талаар ялгаа заагийг оновчтой зөв гаргасан харьцуулсан болон практик судалгааг хийж болох юм.

График №20 Татварын маргаантай холбоотой




Захиргааны эрх зүйд татварын маргааны дотор эрэлттэй байгаа сэдэв нь нийслэлийн шүүгчдийн 10 хүний 9 нь татварт ногдох зүйлийн тодорхойлохтой холбоотой маргаан гэжээ. Орон нутгийн шүүгчдийн хувьд татварын хөнгөлөлт, чөлөөлөхтэй холбоотой маргааныг 10 шүүгчийн 7 нь хэрэгцээт сэдэв гэж сонгожээ.

График №21 Улсын бүртгэлтэй холбоотой маргаан



Улсын бүртгэлтэй холбоотой маргааны хувь орон нутаг, нийслэлийн шүүгчид өөр өөр байр суурьтай байна. Орон нутагт эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой маргаан (65.2%) эрэлт хэрэгцээтэй байгаа бол нийслэлд иргэний бүртгэлтэй холбоотой маргаан (63.6) эрэлт хэрэгцээтэй байна.

График №22 Сонгуулийн маргаантай холбоотой



Сонгуулийн маргаантай холбоотой сэдэв дотроос орон нутаг болон нийслэлд 10 шүүгчийн 7 нь санал хураалт, санал тоолох ажиллагаатай холбогдсон маргааныг илүү чухал гэж үзжээ.

Дээрх төрлийн маргаанаас өөр “Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ойлголт, үйл баримт ижил хэрэгт ашиглах шүүхийн президент бий болгох, НӨАТ, татварын байцаагчийн акт, газрын кадастрын тухай ойлголт авах, албадан дуудлага худалдааны тухай ойлголт”... зэрэг маргааныг судлах, мэдэх эрэлт хэрэгцээ шаардлага байгааг бичгээр дурьджээ.

3. Шүүн таслах ажиллагааны ур чадвар

Хүснэгт №2 Шүүн таслах ажиллагааны ур чадвар

| № | Шүүн таслах ажиллагааны ур чадвар (Judicial Skills) | Маш чухал | Чухал | Чухал биш |
|---|--|--------------|-------|--------------|
| 1 | Шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй | 86 | 13.1 | 0.9 |
| 2 | Шүүх хуралдааныг үр нөлөөтэй удирдан явуулах арга зүй | 49.5 | 48.5 | 2 |
| 3 | Шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод танилцуулах ур чадвар | 53.3 | 43.7 | 3 |
| 4 | Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүй | 86.3 | 12.3 | 1.4 |
| 5 | Хууль зүйн үндэслэгээ тогтоох | 90.2 | 8.8 | 1 |
| 6 | Нотлох баримтыг үнэлэх | 85 | 14.5 | 0.5 |
| 7 | Хэргийн хөдөлгөөний мониторингийн програм хангамжийг ашиглах | 27.1 | 63.3 | 9.5 |

Шүүн таслах ажиллагааны ерөнхий ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр судалгаа, мэдээлэл, сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлбол хэргийн үйл баримтад хууль зүйн үндэслэгээ гаргах (90.2%), эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүй (86.3%), шүүхийн шийдвэрийг боловсруулах арга зүйг (86%) “**маш чухал**” гэж үзсэн бол шүүх хуралдааныг үр нөлөөтэй удирдан явуулах (48.5%), мэтгэлцээнийг идэвхижүүлэх, хэргийн хөдөлгөөний мониторингийн програм хангамжийг ашиглах (63.3%), шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод тайлбарлах (43.7%) ур чадварыг “чухал” гэж тооцжээ.

Шүүн таслах ажиллагааны ур чадвар хөгжүүлэх сэдвүүдээс “маш чухал” гэж үзсэн шүүгчдийн шүүгчээр ажилласан хугацаагаар дүн шинжилгээ хийж үзвэл 1-5 жил ажилласан шүүгчид хэргийн хөдөлгөөний мониторингийн програм хангамж ашиглахаас бусад арга зүй, чадварыг нийтэд нь маш чухал гэж үзжээ. Харин 16-аас дээш ажилласан, шүүхийн практик хуримтлуулсан шүүгчид шүүхийн шийдвэр боловсруулах, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүй, хууль зүйн үндэслэгээ тогтоох чадвар зэрэг чиглэлд түлхүү ач холбогдол өгсөн байна.

Хүснэгт.3 Шүүн таслах ажиллагааны ур чадвар “Маш чухал” (Шүүгчээр ажилласан жилээр)

| № | Шүүн таслах ажиллагааны ур чадвар (Judicial Skills) | 1-5 жил | 6-10 жил | 11-15 жил | 16-аас дээш жил |
|---|--|---------|-------------|--------------|-----------------------|
| 1 | Шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй | 87.1 | 85 | 90.3 | 84.7 |
| 2 | Шүүх хуралдааныг үр нөлөөтэй удирдан явуулах | 67.7 | 43.4 | 61.5 | 43.3 |
| 3 | Шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод танилцуулах ур чадвар | 67.7 | 57.9 | 50 | 42.4 |
| 4 | Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүй | 93.3 | 87.3 | 85.7 | 82.4 |
| 5 | Хууль зүйн үндэслэгээ тогтоох | 96.9 | 84.2 | 96.3 | 91.4 |
| 6 | Нотлох баримтыг үнэлэх | 96.9 | 85.7 | 79.3 | 81.2 |
| 7 | Хэргийн хөдөлгөөний мониторингийн програм хангамжийг ашиглах | 30 | 23 | 25.9 | 30.9 |

Үүнээс үзвэл шүүн таслах ажиллагааны ур чадвар хөгжүүлэх чиглэлээр судалгаа, мэдээллийн ажлыг нийтлэг байдлаар, сургалтыг шүүгчдийг зорилтот бүлэгт хуваарилах аргаар буюу шүүхийн практик туршлагаар нь ангилж явуулах нь зүйтэй гэж дүгнэж байна. Залуу шүүгчдийн хувьд хууль зүйн үндэслэгээ тогтоох, нотлох баримтыг үнэлэх ... зэрэг эхэнд байгаа бол ахимаг насны шүүгчдэд хууль зүйн үндэслэгээ тогтоох, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүй ... зэрэг дараалан жагсчээ.

4. Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн хүчин зүйлийг тооцох

Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн хүчин зүйлсийг тооцох нь иргэдэд хүрэх шударга ёсны үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд ач холбогдолтой гэж үзэх болжээ. Шүүн таслах ажиллагаанд холбогдох нийгмийн хүчин зүйлс нь хэрэг маргааныг шийдвэрлэхийн тулд авч үзвэл зохих өргөн хүрээний, олон талт асуудлаар тодорхойлогддог бөгөөд ихэвчлэн хүмүүсийн нийгмийн дунд эзлэх байр суурь, ялгамжит байдалд тулгуурладаг³.

Тухайлбал, Канад Улсын шүүгчийн ёс зүйн зарчимд “Шүүгч нь шүүхийн шийдвэр гаргахаас өмнө хуулийн дагуу бүх этгээдэд тэгш үйлчилж, өөрийгөө тэрхүү шаарлагад нийцүүлэн удирдан жолоодох, хөгжүүлэх шаардлагатай” гэж заажээ. Энэ нь шүүгчээс тухайн хэрэг маргаантай холбоотой нийгмийн хүчин зүйлсийн талаар ойлголт, мэдлэгтэй байж хэвшмэл (stereotype) үзэл хандлага, мухар сүсэг, цуу яриа зэрэгт автахгүйгээр шийдвэр гаргахыг шаардана гэсэн үг юм⁴.

Судалгааны оролцогчид шүүн таслах ажиллагаанд холбогдох нийгмийн хүчин зүйлүүдийн талаарх ойлголт, мэдлэгийн хэрэгцээг дор дурдсан хүснэгтэд дурдсанаар тодорхойлсон байна.

Хүснэгт №3 Нийгмийн хүчин зүйлс

| № | Чиглэл, сэдэв | Байнга | Хааяа | Огт үгүй |
|---|--|--------|-------|----------|
| 1 | Хүчирхийлэл, түүний нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн үр дагавар | 22.5 | 67.5 | 10 |
| 2 | Насанд хүрээгүй хэргийн оролцогч | 27.9 | 61.4 | 10.6 |
| 3 | Төлбөрийн чадваргүй хэргийн оролцогчийн нийгэм, сэтгэл зүйн онцлог | 25.8 | 67.2 | 7.1 |
| 4 | Хөгжлийн бэрхшээл, түүний хэлбэр, үр дагавар | 11.5 | 70.8 | 17.7 |
| 5 | Ялгаварлан гадуурхах: үндэс угсаа, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлах | 9.9 | 46.9 | 43.2 |
| 6 | Бэлгийн чиг баримжааны ялгаанд шударга ёсны үүднээс хандах | 11.6 | 50.3 | 38.1 |
| 7 | Ядуурал ба түүний нийгмийн үр дагаврууд | 40.8 | 46.4 | 12.7 |

³ The National Judicial institute of Canada (2009) Integration protocols for social context

⁴ The National Judicial institute of Canada (2009) Integration protocols for social context

| | | | | |
|---|--|------|------|------|
| 8 | Донтох эмгэг үүсэх шалтгаан нөхцөл, түүний бие махбод, сэтгэлзүйн нөлөөлөл | 20.6 | 54.6 | 24.7 |
| 9 | Хэл, соёлын ялгаатай хүчин зүйлсийг шүүн таслах ажиллагаанд авч үзэх нь | 5.7 | 49.7 | 34.6 |

Судалгаанд хамрагдсан шүүгчид ойлголт, мэдлэгтэй байхыг хамгийн ихээр шаарддаг чиглэл, сэдвүүдэд ядуурал ба түүний нийгмийн үр дагаварууд (40.8%), насанд хүрээгүй хэргийн оролцогч (27.9%) гэж үзсэн байна.

Ерөнхийдөө шүүгчид ойлголт мэдлэгтэй байх шаардлагатай чиглэл, сэдвүүдийг “байнга” болон “хааяа” гэсэн хариултын хувийн нийлбэрээр харуулбал 1) төлбөрийн чадваргүй хэргийн оролцогчийн нийгэм, сэтгэл зүйн онцлог (96.9%), 2) хүчирхийлэл түүний нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн үр дагавар (90%), 3) насанд хүрээгүй хэргийн оролцогч (89.4%) гэсэн сэдвийг онцолжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 10 шүүгч тутмын 9 нь хэрэг хянан шийдвэрлэхэд дурдсан чиглэлээр ойлголт, мэдлэгтэй байхыг шаарддаг гэсэн байна.


Хүснэгт №3 Нийгмийн хүчин зүйлс “Байнга” (Шүүгчээр ажилласан жилээр)

| № | Чиглэл, сэдэв | 1-5 жил | 6-10 жил | 11-15 жил | 16-аас дээш жил |
|---|--|---------|----------|-----------|-----------------|
| 1 | Хүчирхийлэл, түүний нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн үр дагавар | 21.9 | 20.3 | 22.2 | 25.4 |
| 2 | Насанд хүрээгүй хэргийн оролцогч | 31.2 | 25.7 | 38.5 | 24.6 |
| 3 | Төлбөрийн чадваргүй хэргийн оролцогчийн нийгэм, сэтгэл зүйн онцлог | 36.4 | 19.4 | 22.2 | 28.8 |
| 4 | Хөгжлийн бэрхшээл, түүний хэлбэр, үр дагавар | 6.5 | 11.4 | 15.4 | 12.3 |
| 5 | Ялгаварлан гадуурхах: үндэс угсаа, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлах | 6.2 | 12.5 | 16 | 6.3 |
| 6 | Бэлгийн чиг баримжааны ялгаанд шударга ёсны үүднээс хандах | 16.1 | 10 | 18.5 | 8.2 |
| 7 | Ядуурал ба түүний нийгмийн үр дагаврууд | 45.2 | 36.5 | 46.2 | 41.5 |
| 8 | Донтох эмгэг үүсэх шалтгаан нөхцөл, түүний бие махбод, сэтгэлзүйн нөлөөлөл | 22.6 | 18.3 | 22.2 | 21.5 |
| 9 | Хэл, соёлын ялгаатай хүчин зүйлсийг шүүн таслах ажиллагаанд авч үзэх нь | 9.7 | 15.8 | 28 | 13.6 |

Шүүгчдийн ажилласан жилээр харьцуулсан дүнгээс харвал ядуурал ба түүний нийгмийн үр дагаврууд монголын нийгмийн том асуудал төдийгүй шүүгчдийн шийдвэрт тодорхой хэмжээний нөлөөтэй байгаа нь харагдаж байна. Үүний дараа 5 хүртэл ажилласан болон 16 дээш жил ажиллаж байгаа шүүгчдийн хувьд төлбөрийн чадваргүй хэргийн оролцогчийн нийгэм сэтгэлзүйн онцлог байгаа бол 6-аас 15 жил ажиллаж байгаа шүүгчдийн хувьд насанд хүрээгүй хэргийн оролцогч гэж үзжээ.

Дээрх хүснэгтэд дурдсан чиглэлээр ямар төрлийн мэдлэг, мэдээлэл илүү шаардлагатай талаар шүүгчид авч үзэхдээ:

График №18 Шаардлагатай мэдээлэл



Шүүн таслах ажиллагаанд холбогдох нийгмийн хүчин зүйлсийн талаарх мэдлэг, мэдээллийн агуулгад онолын суурь мэдлэг (45.7%), олон улсын сайн туршлага (43.4%)-ын зэрэгцээ өнөөгийн байдал, чиг хандлага, түүнд хийсэн дүн шинжилгээ (80.8%) бүхий байвал илүү хэрэгтэй гэж үзсэн байгаагаас харвал харьцуулалт, онолын судалгаа гэхээс илүүтэйгээр практик судалгаа, одоо байгаа нийгмийн хүчин зүйлсүүдээ судлах, тайлбарлах, баримжаалах шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Харин дээр дурьдсан чиглэлийн дагуу хичээл заах хүн ямар хүн байх талаар сонгохдоо:

График №19 Хичээл заах хүн



Харин энэ төрлийн сургалтыг удирдан чиглүүлэх хүн нь шүүхийн ажлын туршлагатай шүүгч-багш (67.3%) тухайн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаач (62.7%) байх шаардлагатай гэж үзжээ. Эндээс дүгнэвэл шүүн таслах ажиллагаанд холбогдох нийгмийн хүчин зүйлийн талаар сургалт явуулах багш нар нь шүүхийн ажлын туршлагатай шүүгч болон тухайн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн холимог баг байх нь илүү оновчтой болж байна. *Мөн сэтгэл судлаач болон хэл ярианы заах арга зүй сайтай хүнээр заалгах хүсэлтэй байгаа талаар бичгээр санал гарсан.*

5. Хувь хүний хөгжлийн чиглэлээр

Шүүгч гагцхүү хуулийг баримтлан, өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан хэрэг маргааныг шийдвэрлэдэг. Энэ нь шүүгчээс тал бүрийн мэдлэг, ур чадвартай байхыг шаарддаг. Байгууллагын хөгжилд нөлөөлөх олон хүчин зүйлс байдгийн нэг нь хувь хүний хөгжил юм. Өөрөөр хэлбэл шүүхээс үзүүлэх шударга ёсны үйлчилгээний чанар, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд шүүгчийн хувь хүнийхээ хувьд хөгжсөн байдал чухал нөлөөтэй гэсэн үг юм.

Хүснэгт №4 Таны хувьд дараах чиглэлээс аль нь чухал болохыг тодорхойлно уу?

| № | Сэдвүүд | Маш чухал | Чухал | Чухал биш |
|---|----------------------|-----------|-------|-----------|
| 1 | Манлайллын ур чадвар | 49.3 | 45.3 | 5.5 |

| | | | | |
|----|---|------|------|-----|
| 2 | Үр дүнтэй суралцах ур чадвар: өөрийн үнэлгээ хийх, суралцах хэв маягаа тодорхойлох нь | 56.6 | 42.9 | 0.5 |
| 3 | Багаар ажиллах ур чадвар | 48.7 | 47.2 | 4.1 |
| 4 | Харилцааны ур чадвар | 79.8 | 18.8 | 1.4 |
| 5 | Стрессийг бууруулах, даван туулах чадвар | 53.8 | 44.3 | 1.9 |
| 6 | Хувийн зохион байгуулалт: цаг төлөвлөлт, зохицуулалт | 70.6 | 28.9 | 0.5 |
| 7 | Шийдвэр гаргах ур чадвар | 91.3 | 8.7 | 0 |
| 8 | Илтгэх ур чадвар | 55.6 | 42.4 | 2 |
| 9 | Хурал, уулзалтыг удирдах, чиглүүлэх ур чадвар | 47.5 | 50 | 2.5 |
| 10 | Зорилгоо тодорхойлох, карьерийн төлөвлөгөө боловсруулах | 37.2 | 54.6 | 8.2 |
| 11 | Зөрчлийг шийдвэрлэх/ зайлсхийх/ урьдчилан сэргийлэх | 54 | 42.5 | 3.5 |

Хувь хүний хөгжилтэй холбоотой сургалтын чиглэл, сэдвүүдийг үнэлэхдээ ерөнхийд нь чухал гэж үзжээ. Шүүгчдэд маш чухал хэрэгцээтэй хувь хүний хөгжлийн ур чадваруудад шийдвэр гаргах (91.3%), харилцаа (79.8%), хувийн зохион байгуулалт (70.6%) зөрчлийг шийдвэрлэх /зайлсхийх/, илтгэх ур чадвар (55.6%), урьдчилан сэргийлэх (54%)–ийг багтаажээ.


Хүснэгт №5 “Маш чухал” (Шүүгчээр ажилласан жилээр)

| № | Сэдвүүд | 1-5 жил | 6-10 жил | 11-15 жил | 16-аас дээш жил |
|----|---|---------|----------|-----------|-----------------|
| 1 | Манлайллын ур чадвар | 50 | 57.3 | 40.7 | 43.3 |
| 2 | Үр дүнтэй суралцах ур чадвар: өөрийн үнэлгээ хийх, суралцах хэв маягаа тодорхойлох нь | 74.2 | 51.3 | 69.2 | 49.2 |
| 3 | Багаар ажиллах ур чадвар | 65.6 | 53.4 | 42.9 | 37.5 |
| 4 | Харилцааны ур чадвар | 93.8 | 72.4 | 85.7 | 79.2 |
| 5 | Стрессийг бууруулах, даван туулах чадвар | 65.6 | 51.9 | 58.6 | 48.6 |
| 6 | Хувийн зохион байгуулалт: цаг төлөвлөлт, зохицуулалт | 71.9 | 74 | 58.6 | 71.2 |
| 7 | Шийдвэр гаргах ур чадвар | 97.1 | 88.9 | 96.7 | 89.2 |
| 8 | Илтгэх ур чадвар | 70.6 | 53.2 | 48.1 | 53.7 |
| 9 | Хурал, уулзалтыг удирдах, чиглүүлэх ур чадвар | 61.8 | 51.4 | 34.5 | 41.3 |
| 10 | Зорилгоо тодорхойлох, карьерийн төлөвлөгөө боловсруулах | 39.4 | 32.9 | 44 | 38.1 |
| 11 | Зөрчлийг шийдвэрлэх/ зайлсхийх/ урьдчилан сэргийлэх | 64.5 | 55.3 | 57.1 | 46.2 |

Хувь хүний хөгжлийн хувийн ур чадваруудыг шүүгчдийн ажилласан жилээр харьцуулвал нийт дүнгээс тийм ч өөрчлөгдөхгүй байна. 1-5 жил ажилласан шүүгчдийн хувьд шийдвэр гаргах арга зүй, ур чадвар (97.1%), харилцааны ур чадвар (93.8%), үр дүнтэй суралцах ур чадвар (74.2%) гэж үзсэн бол ажилласан жил ихсэх тусам эдгээр чиглэлийн мэдлэг мэдээлэл авах, сургалтад хамрагдах эрэлт хэрэгцээ харьцангуй буурч байгаа нь ажиглагдаж байна. Судалгааны дүнгээс шүүгчдэд хувь хүний хөгжлийн чиглэлээр мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн сургалт явуулах хэрэгцээ байгааг шүүгчид өөрсдөө илэрхийлсэн бөгөөд хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Харин энэ төрлийн сургалтад 37.5% буюу 10 шүүгчийн 4 орчим нь 17 –оос дээш цагийг нэг жилийн хугацаанд зарцуулах боломжтой

байдаг гэсэн байна. Хамгийн бага буюу 8.3% нь энэ төрлийн сургалтад 4 хүртэл цаг зарцуулах боломжтой гэжээ. Эндээс дүгнэвэл шүүгчид хувь хүний хөгжлийн чиглэлээр сургалтад хамрагдах сонирхол их байгааг ахин нотлож байна.

График №20 Та нэг жилийн хугацаанд хувь хүний хөгжлийн чиглэлээр ямар хугацаанд сургалтанд хамрагдах боломжтой вэ?



6. Салбар хоорондын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх

Нийгэм, эдийн засгийн харилцаа, техник технологи улам бүр эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед шүүгчид зөвхөн эрх зүйн мэдлэг, шүүн таслах ажиллагааны ерөнхий ур чадвараар ээдрээ төвөгтэй хэрэг маргааныг шийдвэрлэх бололцоо хязгаарлагдмал болж байна.⁵ Салбар хоорондын мэдлэг, ур чадвар хөгжүүлэх чиглэлийн асуулгаас шүүгчид шүүн таслах ажиллагаан дахь сэтгэл судлал (67.6%), шүүгчид санхүү, нягтлан бодох бүртгэл (52.7%), олон нийттэй харилцах харилцааны ур чадвар (52.5%), кибер орчин ба эрх зүйн (44.8%) чиглэлийг шүүн таслах ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд **маш чухал** гэж үзсэн байна.

Хүснэгт №6 Хэрэг маргааныг үр нөлөөтэй шийдвэрлэхэд эрх зүйн мэдлэг, ур чадвараас гадна бусад салбарын шаардлагатай мэдлэг, ур чадварыг тодорхойлно уу.

| № | Салбар дундын мэдлэг, ур чадвар (Interdisciplinary Courses) | Маш чухал | Чухал | Чухал биш |
|----|---|-----------|-------|-----------|
| 1 | Санхүү, нягтлан бодох бүртгэл | 52.7 | 45.8 | 1.8 |
| 2 | Менежментийн ур чадвар | 18.1 | 70.9 | 11 |
| 3 | Шүүгчээс олон нийттэй харилцах харилцааны ур чадвар | 52.5 | 47 | 0.5 |
| 4 | Цахим орчин ба эрх зүй | 44.8 | 52.7 | 2.5 |
| 5 | Шүүн таслах ажиллагаа ба харилцааны сэтгэл судлал | 67.6 | 32.4 | 0 |
| 6 | Эрх зүй ба философи | 41.8 | 53.1 | 5.2 |
| 7 | Спорт, урлаг ба эрх зүй | 9.9 | 67 | 23.1 |
| 8 | Анагаах ухаан ба эрх зүй | 30.7 | 56.6 | 12.7 |
| 9 | Стресс менежмент | 32 | 59.3 | 8.8 |
| 10 | Шүүх эмгэг, сэтгэц судлал | 40.8 | 59.2 | 0 |

Шүүн таслах ажиллагаан дахь менежмент (70.9%), эрх зүй ба урлаг, спорт (67%), стресс менежмент (59.3%), шүүх эмгэг, сэтгэц судлал (59.2%), кибер орчин ба эрх зүйн (52.7%) чиглэлийг “чухал” гэж үзсэн байна. Мөн шүүгчдээс “Орчин үеийн шүүгчдийн нийгэмд

⁵ Dr. Rainer Hornung, *Taking into Account Non-Judicial Aspects Matters in Judicial Training Programs for Judges and Prosecutors*, Judicial Education and Training by IOJT, Vol. 1 2013, p.45

гүйцэтгэх үүрэг, дүр төрх”, “эдийн засаг ба эрх зүй”, “Физикийн хуулиуд ба эрх зүй”, “сэтгэл судлал”, “гадаад хэл” зэрэг чиглэлээр судалгаа мэдээлэл авах, сургалтад оролцох санал дэвшүүлснийг салбар хоорондын мэдлэг, ур чадварын сургалтын агуулгыг тодорхойлоход анхаарч үзэх нь зүйтэй байна. Цааш шүүхэд ажилласан жилээр харьцуулж харвал:

Хүснэгт №7 Шаардлагатай мэдлэг, ур чадвар “Маш чухал” (Шүүгчээр ажилласан жилээр)

| № | Салбар дундын мэдлэг, ур чадвар (Interdisciplinary Courses) | 1-5 жил | 6-10 жил | 11-15 жил | 16-аас дээш жил |
|----|---|---------|----------|-----------|-----------------|
| 1 | Санхүү, нягтлан бодох бүртгэл | 58.8 | 57.1 | 63 | 40 |
| 2 | Менежментийн ур чадвар | 21.9 | 14.4 | 20.8 | 15.8 |
| 3 | Шүүгчээс олон нийттэй харилцах харилцааны ур чадвар | 58.8 | 48.7 | 59.3 | 50.8 |
| 4 | Цахим орчин ба эрх зүй | 45.5 | 41.8 | 38.5 | 50.8 |
| 5 | Шүүн таслах ажиллагаа ба харилцааны сэтгэл судлал | 82.4 | 60 | 69.2 | 68.1 |
| 6 | Эрх зүй ба философи | 30.3 | 41.7 | 53.8 | 42.9 |
| 7 | Спорт, урлаг ба эрх зүй | 6.2 | 15.7 | 16.7 | 1.8 |
| 8 | Анагаах ухаан ба эрх зүй | 47.1 | 30.1 | 33.3 | 20.7 |
| 9 | Стресс менежмент | 39.4 | 28.8 | 32 | 31.7 |
| 10 | Шүүх эмгэг, сэтгэц судлал | 42.6 | 41.9 | 36.2 | 40.1 |

Шүүн таслах ажиллагаа ба харилцааны сэтгэл судлал бүх насны шүүгчдэд маш чухал хэрэгтэй байгаа нь харагдаж байгаа боловч 5 хүртэл ажилласан шүүгч (82.4%)-ээс дээшээ эрэлт хэрэгцээ нь буурч, цахим орчин ба эрх зүй нь 5 хүртэл ажилласан шүүгч (45.5%)-ээс дээш өссөн байна. Нийтэд нь шүүгчидэд харилцаа, олон нийттэй харилцах ур чадварын сэдвүүд эрэлт хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Салбар эрх зүйн хүрээнд асуултад дурдсан дэд сэдвүүдээс эрэлттэй нь дараах сэдвүүд байна. **Эрүүгийн эрх зүй:** Цахим мэдээлэлд хууль бусаар халдах 79.1%, Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг 74.5%, Мөнгө угаах 72.5%, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай ойлголт 67.1%, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 62.9%, Хүүхдэд ял оногдуулах онцлог, ял хариуцлагын арга хэмжээний төрлүүд, тэдгээрийн үр нөлөө 62.7%, Эрүүгийн процессын эрх зүйн тогтолцоо 64.9%, Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах 63.3%, Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 54.9%... байдалтай байгаа бол, **Иргэний эрх зүй:** Компаниас их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг зөрчсөнтэй холбоотой маргаан 75.5%, Гэрлэгчид хоорондын эд хөрөнгийн маргаан 73.5, Олон улсын гэрээ, гадаад улсын хуулийг хэрэглэх асуудал 71.5, Даатгалын нөхөн төлбөр, хураамж төлөхтэй холбоотой маргаан 63.8%, Санхүүгийн түрээсийн гэрээтэй холбоотой маргаан 62.7%, Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, буруу оногдуулсан тухай маргаан 62.2% ... , Захиргааны эрх зүй: Татвар ногдох зүйлийг тодорхойлохтой холбоотой маргаан 74%, Захиргааны эрх зүйн гэрээг хувийн эрх зүй дэх гэрээнээс ялган зүйлчлэх асуудал 71,8%, Санал хураалт, санал тоолох ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх 68.2%, Захиргааны байгууллага, албан тушаалтны хэлбэржээгүй үйл ажиллагаа 58.5%, Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой маргаан 51.4% байгаа нь нэн тэргүүнд дээрхи сэдвүүдээр судалгаа, сургалт, мэдээлэл түгээж ажиллах нь зөв юм.

Шүүн таслах ажиллагааны ур чадварын хүрээнд хэргийн үйл баримтад хууль зүйн үндэслэгээ гаргах, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх арга зүй, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй... зэрэг чадварууд маш эрэлт хэрэгцээтэй, чухал байгаа тул дээрх сэдвүүдээр чадвартай мэргэжлийн хүмүүсээр зөвлөх үйлчилгээг авч судалгаа, мэдээлэл гаргах хэрэгтэй байна. Мөн удахгүй ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн шинэ шүүгчид томилогдвол бүр ч илүү эрэлт хэрэгцээтэй байх дамжиггүй.

Шүүн таслах ажиллагаанд нийгмийн хүчин зүйлийг тооцох нь шүүхээс үзүүлж буй шударга ёсны үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах ач холбогдолтой бөгөөд төлбөрийн чадваргүй хэргийн оролцогчийн нийгэм, сэтгэл зүйн онцлог, хүчирхийлэл түүний нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн үр дагавар, насанд хүрээгүй хэргийн оролцогч гэсэн сэдвүүдийг онцолжээ. Судалгаанд хамрагдсан 10 шүүгчийн 9 нь дээр дурдсан чиглэлээр ойлголт, мэдлэгтэй байхыг ихээр шаарддаг гэсэн байдгаас харвал сургалт семинар явуулахдаа дээрх чиглэлээр нэн тэргүүнд нь явуулах хэрэгтэй байна.

Судалгааны дүнгээс шүүгчдэд хувь хүний хөгжлийн чиглэлээр мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн сургалт явуулах хэрэгцээ байгаа нь илэрхий харагдаж байсан бөгөөд бүх чиглэлүүд ерөнхийдөө өндөр хувиар эрэлттэй байна. Үүнээс эхний гурвыг дурьдвал: 1) Шийдвэр гаргах (91.3%), 2) Харилцаа (79.8%), 3) Хувийн зохион байгуулалт: цаг төлөвлөлт, зохицуулалт (70.6%)... байна.

Харин энэ төрлийн сургалтад 37.5% буюу 10 шүүгчийн 4 орчим нь 17 –оос дээш цагийг нэг жилийн хугацаанд зарцуулах боломжтой байдаг гэсэн байна. Хамгийн бага буюу 8.3% нь энэ төрлийн сургалтад 4 хүртэл цаг зарцуулах боломжтой гэжээ. Эндээс дүгнэвэл

шүүгчид хувь хүний хөгжлийн чиглэлээр сургалтад хамрагдах сонирхол их байгааг ахин нотлож байна.

Салбар хоорондын мэдлэг, ур чадвар хөгжүүлэх чиглэлийн асуулгаас шүүгчид шүүн таслах ажиллагаан дахь сэтгэл судлал (67.6%), шүүгчид санхүү, нягтлан бодох бүртгэл (52.7%), олон нийтгэй харилцах харилцааны ур чадвар (52.5%), кибер орчин ба эрх зүйн (44.8%) чиглэлийг шүүн таслах ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд **маш чухал** гэж үзсэн байна.

Шүүн таслах ажиллагааны ур чадвар хөгжүүлэх, салбар хоорондын мэдлэг, ур чадвар олгох, хувь хүний ур чадвар хөгжүүлэх зэрэг чиглэлийн судалгаа, мэдээлэл, сургалтын эрэлт хэрэгцээ нийт шүүгчдэд нэн тэргүүн эрэлт хэрэгцээтэй байна. Харин шүүгчээр 1-5 хүртэл жил ажилласан буюу залуу шүүгчдэд энэ сэдэв өндөр хувиар хэрэгцээтэй байгаа бол шүүн таслах ажиллагааны туршлагатай шүүгчдийн хувьд эдгээр чиглэлийн сургалтын эрэлт хэрэгцээ харьцангуй бууралттай үзүүлэлттэй байна.

